

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

## Г Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт г оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 23.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1.2, “Бааз” ХК 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын 02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бааз” ХК-ийн оноосон нэрийг “Монголиа-Инфраструкча” ХК болгон өөрчилж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Монголиа-Инфраструкча” ХК /Б.Отгонтуяа/-д үүрэг болгосугай.

3. Энэ тухай Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН